



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/71

Онги

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дүгээр зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр Сайхан-Овоо суманд Хогийн машин худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Үнэлгээний хорооны дарга: Цэцэрлэгийн арга зүйч (М.Мөнгөнтуяа)

Нарийн бичгийн дарга: Ерөнхий боловсролын сургуулийн захирал

(Б.Арсланбаатар)

Гишүүн: Архив, бичиг хэргийн эрхлэгч (О.Дашзэвгэ)

Хөндлөнгийн гишүүд: Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Э.Отгонцэцэг)

Тусгай сан хариуцсан нягтлан бодогч (Э.Наранцэцэг)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (М.Мөнгөнтуяа)-д даалгасугай

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Арсланбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА